

Популяц

Популяц

Популяц нь экологийн шинжлэх ухааны нэг салбар бөгөөд бүх амьд организмууд популяцын хэлбэрт оршдог.

Популяц "populus" ард түмэн гэдэг латин үгнээс гаралтай.







Популяц гэдгийг биологийн ухааны салбар бүр өөр өөр өвөрмөц байдлаар тодорхойлдог. Үүнд:

- ❖ Амьтан судлалын ухаанд популяц бол ареал тархац нутгийн ямар нэг тодорхой хэсгийг эзэлж байгаа, зүйлийн нэгдэл суурьшил гэнэ.
- ❖ Экологийн ухаанд популяцыг өөр хоорондоо холбоотойгоор тухайн зүйлийн ерөнхий тархац нутгийг хамтдаа эзэмшин орших, нэг зүйлийн бүлэг бодгаль биеийг хэлнэ.



❖ **Эволюцийн онолд** популяц бол тодорхой газар нутаг буюу зүйлийн тархац нутгийн тодорхой хэсгийг эзлэн оршдог бүлэг бие махбод юм.

❖ **Генетикт популяц** бол хоорондоо удам төрлийн ба үржлийн холбоотой бодгалиудын нийлбэр мөн.



*Нэгдмэл нэг газар нутагт хамт оршин амьдарч, бие биедээ байнга харилцан нөлөөлдөг, хүрээлэн буй орчны өөрчлөлтийг тэсвэрлэн, тоо толгой, төлөв байдлаа удаан хугацаанд тогтмол хамгаалдаг нэг зүйлийн бүлэг бодгалийг **популяц** гэнэ.*



Популяцын ангилал

Популяцыг оршин тогтнож буй орон зайн хувьд 3 ангилна.



- 1. Газарзүйн популяц*
- 2. Экологийн популяц*
- 3. Эгэл популяц*



Газар зүйн популяц. Байгал, цаг уурын нэг бүс нутгийн хүрээнд хамаарах өөр өөр биогеноценозод оршин амьдарч буй популяцуудийг **газар зүйн популяц** гэнэ.


Экологийн популяц. Нэг биогеноценозийн хүрээнд оршин амьдардаг, фенотипийн /харагдах байдал/ хувьд ижил, зүйлийн доторх орон зайн хязгаарлагдмал бүлэглэлийг хэлнэ.

Эгэл популяц. Бага хэмжээтэй, нэг төрлийн органик амьдрагч бүлэг бодгалиудыг хэлнэ. Энэ нь популяцын хамгийн энгийн жижиг хэлбэр



Экологийн
популяц

Зүйлийн
эзэмшил нутаг



Энгийн
популяц

Газарзүйн
популяц



